



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 11 сарын 05 өдөр

Дугаар САШ-2025/15

Сүхбаатар сум

Цагааннуур сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн  
Хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан  
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн СХШ-2025/25/-ТШЗ дугаартай “Санхүүгийн хяналтын ажлын удирдамж”-аар Цагааннуур сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дотоод аудитор, СХШУБ Ц.Уртнасан 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс ажлын 15 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Цагааннуур сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал (цаашид Цагааннуур сумын ИТХ гэх)-ын 2023 оны 10 сарын 01 өдрөөс 2025 оны 09 сарын 30 өдөр хүртэлх хугацааны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Цагааннуур сумын ИТХ нь улсын бүртгэлийн 3762629 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130754001 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100130754401 дугаартай дансуудыг ашиглаж байна.

1.5. Цагааннуур сумын Төсвийн орлого, зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг Цагааннуур сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Болортуяа, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Д.Энхжаргал нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6. Цагааннуур сумын ИТХ нь улс төрийн албан тушаалтан 1, төрийн захиргааны албан хаагч 2 нийт 3 хүний орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

4325001147

1.7. Цагааннуур сумын ИТХ нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвлөл болон Нутгийн удирдлага, хууль зүйн бодлогын хороо, Дэд бүтэц хөгжлийн бодлогын хороо, Нийгмийн бодлогын хороо, ХАА, байгаль орчны бодлогын хороо Эдийн засаг төсвийн бодлогын хороо, Өргөдөл гомдлын бодлогын хороо зэрэг 6 бодлогын хороог байгуулж, хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж байна. /Хүснэгт 1 харуулав/

1.8. Сумын ИТХ болон ИТХ-ын Зөвлөлийн хуралдаан, багийн иргэдийн Нийтийн Хуралдаан, сургалт, бодлогын хороодын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэгт ажлын албаны зүгээс анхаарч ажилласан байна.

Хүснэгт .1

№	Огноо	ИТХ -ын хуралдсан тоо	ИТХ-ын зөвлөлийн хуралдсан тоо	ИТХ-ын хороодын хуралдсан тоо	БИНХ-ын хуралдсан тоо
1	2023	8 /31 асуудал хэлэлцэж 31 тогтоол баталсан байна/	6	3 /хяналт шалгалтын 1 ажил зохион байгуулсан/	4 / 3 баг ИНХ-ын хуралдаан зохион байгууснаас 3-р баг 2 удаа/
2	2024	8 36/ асуудал хэлэлцэж 36 тогтоол баталсан байна/	6	3 /хяналт шалгалтын 1 ажил зохион байгуулсан/	3 /3 баг ИНХ-ын хуралдаан зохион байгуулсан/
3	2025 оны 3 улирал	5 /15 асуудал хэлэлцэж 14 тогтоол баталсан байна/	2	-	3 /3 баг ИНХ-ын хуралдаан зохион байгуулсан/

### Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Цагааннуур сумын ИТХ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

2.1.2 Цагааннуур сумын ИТХ-ын төсвийн хөрөнгийг зарцуулах захиргааны шийдвэр гаргахдаа Захиргааны актад утга, агуулгын алдаагүй бодит нөхцөл байдлыг тогтоосон эрх зүйн үндэслэл хэсэгт нарийвчилсан зохицуулалтай хуулийн заалт, болон хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актын зүйл заалтыг ашиглаж байна.

## 2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

### 2.2.1 Батлагдсан төсөв:

Цагааннуур сумын ИТХ-ын тогтоолоор тус байгууллагын төсвийг санхүүжүүлэхээр 2023 онд 115,508.5 мянган төгрөг, 2024 онд 196,867.1 мянган төгрөг, 2025 онд 254,466.6 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

№	Огноо	ИТХ-ын тогтоолын огноо, дугаар	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү /үлдэгдэл	Хувь
1	2023	2023 оны 08 сарын 03 өдрийн 99 тогтоол  Засаг даргын 2023 оны 10 сарын 23 өдрийн А/141 захирамж	115,508.5  131,402.3	  130,701.1	  701.2	  99.5
2	2024	2024 оны 09 сарын 25 өдрийн 127 тогтоол	196,867.1	195,272.4	1,594.7	99.2
3	2025	2024 оны 12 сарын 30 өдрийн 13 тогтоол	254,466.6	184,533.9		
	2025 -3 улирал		200,579.6	184,533.9	16,045.7	92.0

Цагааннуур сумын Засаг даргын 2023 оны А/141 захирамжаар Төсвийн тухай хуулийн 34.2.2, 42.2.2, 43.3.1 дахь заалтыг үндэслэн нийт 15,894.0 мянган төгрөгийг ЭМТ, Цэцэрлэгийн төсвөөс зохицуулалт хийж нэмэгдүүлсэн байна.

2023 онтой харьцуулахад 2024 онд батлагдсан төсөвт орсон өөрчлөлт:

- Засгийн газрын 2024 оны 82 тогтоолын дагуу цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 52,642.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 6,862.1 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардал 944.8 мянган төгрөгөөр, нормативт зардал 58.8 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 2,135.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 2,407.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 2,989.6 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 1,400.0 мянган төгрөгөөр тус тус өссөн дүнтэй батлагдсан байна.

2024 онтой харьцуулахад 2025 онд батлагдсан төсөвт орсон өөрчлөлт:

- Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 2025 онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 32,252.8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3,615.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн,
- Урсгал шилжүүлэг 31377.5 мянган төгрөгөөр /үүнээс хөдөө, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 5 жилийн урамшуулал 17.802.0 мянган төгрөг/ нэмэгдсэн байна.

## 2.2.2 Төсвийн зардлын гүйцэтгэл:

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2023 он		2024 он		2025 оны 3 улирал	
		Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	131,402.3	130,701.1	196,867.1	195,272.4	200,579.6	184,533.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	131,402.3	130,701.1	196,867.1	195,272.4	200,579.6	184,533.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	128,657.3	128,282.8	192,722.1	191,130.4	180,895.2	166,231.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	86,054.3	85,978.6	138,696.6	138,068.4	134,801.3	126,012.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,891.5	10,745.5	17,753.6	17,225.0	16,851.1	15,570.9
2104	Хангамж, бараа материалын зардал	8,600.0	8,599.2	9,544.8	9,534.9	6,029.0	5,574.7
2105	Нормативт зардал	0.0	0.0	58.8	58.8	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,975.4	7,966.0	4,000.0	4,000.0	3,888.8	3,688.5
2107	Томилолт, зочны зардал	2,500.0	2,500.0	4,635.0	4,250.0	3,600.0	2,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,163.3	4,020.6	6,570.9	6,530.9	5,225.0	4,985.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,472.8	8,472.8	11,462.4	11,462.4	10,500.0	8,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,745.0	2,418.3	4,145.0	4,142.0	19,684.4	18,302.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	131,402.3	130,701.1	196,867.1	195,272.4	200,579.6	184,533.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	131,402.3	130,701.1	196,867.1	195,272.4	200,579.6	184,533.9

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг 2023 онд 130,701.1 мянган төгрөг буюу 99.5 хувь, 2024 онд 195,272.4 мянган төгрөг буюу 99.2 хувь, 2025 оны 3 улирлын байдлаар 184,533.9 мянган төгрөг буюу 92.0 хувиар тайлагнасан байна.

2023 онд нийт 701.2 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 75.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 146.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 142.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 326.7 мянган төгрөг, бусад зардал 10.1 мянган төгрөгийн тус тус зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

2024 онд нийт 1,594.7 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 628.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 528.6 мянган төгрөг, томилолт зочны зардал 385.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 40.0 мянган төгрөг, бусад зардал 12.9 мянган төгрөгийн тус тус зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

2025 оны 3 улирлын байдлаар нийт 16,045.7 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь:

- Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 3 улиралд олгоогүйгээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 8,788.8 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1,280.2 мянган төгрөг хэмнэгдсэн,
- Хангамж, бараа материалын зардал 454.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 200.3 мянган төгрөг, томилолт зочны зардал 1,200.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 239.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 2,500.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 1,382.4 мянган төгрөгийн тус тус зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар дүн шинжилгээ хийхэд төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөсөн байна.

### 2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд:

Хүснэгт 4

(мянган төгрөгөөр)

№	Нэмэлт санхүүжилтийн данс				
	Огноо	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	2023	0.0	300.0	300.0	0.0
2	2024	0.0	0.0	0.0	0.0
3	2025 - 3 улирал	0.0	0.0	0.0	0.0

2023 онд Сэлэнгэ аймгийн ИТХ-ийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 300.0 мянган төгрөг орж ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

### 2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

ИТХ-ын нарийн бичгийн даргын 2023 оны Б/01 дугаар, 2024 оны Б/01 дугаар, 2025 оны Б/01 дугаар тушаалаар ИТХ-ын дарга, хурлын нарийн бичгийн дарга, мэргэжилтний цалинг тус тус шинэчлэн баталсан байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажууллаа.

### 2.4. Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, нэршлийг үнэн зөв хөтөлсөн, орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

Хяналт, шалгалтын явцад санхүүгийн ажилтан албан хаагчидтай хамтарч үндсэн хөрөнгийн тооллого, тулган баталгаажуулалт хийсэн.

#### Үндсэн хөрөнгө:

Хүснэгт 5.

(мянган төгрөгөөр)

№	Үндсэн хөрөнгө				
	Огноо	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	2023	21,449.5	1,884.0	0.0	23,333.5
2	2024	23,333.5	11,025.8	12,020.7	22,338.6
3	2025 - 3 улирал	22,338.6	1,800.5	0.0	24,139.1

2023 онд үндсэн хөрөнгийн орлого:

- Батлагдсан төсвөөс 2 багт байрлах зам дагуу гэрлийн самбар дансны үнэ 1,884.0 мянган төгрөгөөр худалдан авсныг санхүүгийн бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

2024 онд үндсэн хөрөнгийн орлого:

- Батлагдсан төсвөөс гэр интернет 400.0 мянган төгрөгөөр худалдан авсан, элэгдлийн хугацаа нь дууссан prius 20 маркийн автомашин, цаас зүсэгч, 3 үйлдэлт принтерийг 10,625.8 мянган төгрөгөөр дахин үнэлж орлогоор бүртгэснийг санхүүгийн бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

2024 оны үндсэн хөрөнгийн зарлага:

- Цагааннуур сумын ИТХ-ын 2024 оны 16 дугаар тогтоолоор 1,394.9 мянган төгрөгийн хөрөнгө акталсан ба Сэлэнгэ аймгийн ОНӨГ-ын 2024 оны 527 дугаар албан тоотыг үндэслэн 10,625.8 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байна.

2025 оны 3 улирлын байдлаар үндсэн хөрөнгийн орлого:

✚ Батлагдсан төсвөөс ширээ 1, сандал 3, төмөр шүүгээ 1 буюу нийт дансны үнэ 1.800.5 мянган төгрөгөөр худалдан авсныг санхүүгийн бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

Бараа материал:

Хүснэгт 6.

(мянган төгрөгөөр)

№	Бараа материал				
	Огноо	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	2023	0.0	26,777.8	26,777.8	0.0
2	2024	0.0	27,118.2	27,118.2	0.0
3	2025 - 3 улирал	0.0	12,281.6	12,281.6	0.0

2025 оны 3 улирлын байдлаар 12.281.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, зарцуулсан нь баримтаар нотлогдож байна.

**2.2.5. Өглөг, авлагыг санхүүгийн тайланд үнэн зөв бүртгэсэн байдал**

2025, 2024, 2023 оны 3 улирлын байдлаар өр, авлагагүй, байна.

**2.6. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2023, 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

**2.7. Дотоод хяналт шалгалтын үр нөлөө**

2023, 2024, 2025 онд Цагааннуур сумын Засаг даргын “Сумын төсвийн байгууллагуудад төсөв, санхүүгийн талаар дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөө”-г баталсан байна. Сумын санхүүгийн алба нь дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу ИТХ-д 2023 онд 3, 2024 онд 4, 2025 оны 3 улирлын байдлаар 2 хяналтыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Дотоод хяналтаар илэрсэн алдаа зөрчлийн дагуу хийсэн ажлын талаар тайланг бичиж, алдааг тухай бүр залруулж ажилласан байна.

Хүснэгт 7

№	Төлөвлөгөө баталсан огноо	Шалгалтанд хамрагдах асуудал ИТХ-д хамааралтай	Санхүүгийн дотоод хяналт, шалгалт хийгдсэн тоо
1	2023.01.30	19	3
2	2024.01.05	19	4
3	2025.01.15	19	2

**Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал,  
илэрсэн зөрчил дутагдал**

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Цагааннуур сумын ИТХ-ын ажлын албаны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нар төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль, холбогдох журам зааврын дагуу төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан, өмч хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

**Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:**

**4.1 Дүгнэлт:**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Цагааннуур сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Бага” эрсдэлтэйд тооцож дүгнэлээ.

**Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:**

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

**БИЧСЭН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН ДОТООД  
АУДИТОР САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ  
Ц.УРТНАСАН



**ТАНИЛЦСАН:**

ЦАГААННУУР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ч.БОЛОРТУЯА  
НЯГТЛАН БОДОГЧ  
Д.ЭНХЖАРГАЛ

